

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20...оны ..дугаар
сарын..-ны өдөр

Улаанбаатар хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэнд дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Дээд боловсролын зорилго

2.1.Дээд боловсролын зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, олон улсад өрсөлдөх мэдлэг, ур чадвартай, оюунлаг бүтээлч, хариуцлагатай иргэнийг бэлтгэхэд оршино.

3 дугаар зүйл. Дээд боловсролын хууль тогтоомж

3.1.Дээд боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. “ахисан түвшний сургалт” гэж магистр, докторын хөтөлбөрөөр зохион байгуулах сургалтыг;

4.1.2. “үндэсний мэргэшлийн хүрээ” гэж үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрсөн нийтлэг стандарт, мэргэшлийн түвшин тогтоох, эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг хүлээн зөвшөөрөх, тодорхойлох, хөгжүүлэх, үнэлэх үйл ажиллагааг тодорхойлсон бүтцийг;

4.1.3. “судалгааны их сургууль” гэж эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын чанараар тэргүүлэх, улс төрөөс хараат бус, эрдмийн эрх чөлөө,

санхүүжилтийн тогтвортой эх үүсвэртэй, ашгийн төлөө бус, дээд боловсролын эрдэм шинжилгээ-сургалтын байгууллагыг;

4.1.4. “магадлан итгэмжлэл” гэж дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөр нь шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлж, дүгнэх үйл явцыг;

4.1.5. “суралцагчийн тэтгэлэг” гэж суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан олгох буцалтгүй мөнгөн тусламжийг;

4.1.6. “сургалтын зээл” гэж суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлөөр олгох мөнгөн тусламжийг;

5 дугаар зүйл. Дээд боловсролын зарчим

5.1. Дээд боловсролын үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмаас гадна дор дурдсан зарчмыг баримтална.

5.1.1. Эрдмийн эрх чөлөөг дээдлэх;

5.1.2. Суралцагчийн хэрэгцээнд нийцсэн байх;

5.1.3. Ёс зүй, хариуцлагатай байх;

ХОЁРДУГААР БҮЛЭГ:

ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ, НИЙГМИЙН БАТАЛГАА

6 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч түүний эрх, үүрэг

6.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч нь Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаас гадна дараах эрх эдэлнэ:

6.1.1. эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцох;

6.1.2. бүтээлээ хэвлүүлэх;

6.1.3. магистрант, докторант нь оюутанд мэргэжлийн зөвлөгөө өгөх;

6.1.4. докторант нь хичээл заах;

6.1.5. цагийн ажил эрхлэх, гарааны компани байгуулах;

6.1.6. бүтээсэн шинэ мэдлэг, патентаа эзэмших, оюуны өмчийн хамгаалалт хийлгэх.

6.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч нь Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан үүрэг хүлээнэ.

7 дугаар зүйл. Суралцагчийн нийгмийн баталгаа

7.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч нь Боловсролын ерөнхий хуулийн 14 дүгээр зүйлд заасан нийгмийн баталгаанаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана.

7.1.1. Дээд боловсролын сургалтын байгууллага суралцагчийг дадлага хийх, цагийн хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлж, хичээлийн байр, лаборатори, номын сан, нийтийн хоол, биеийн тамирын заалаар үйлчлүүлэх нөхцөлөөр хангана.

7.1.2. Өнчин, тахир дутуу болон амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан хөнгөлөлттэй зээл олгоно.

7.1.3. Сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн зарим хэсгийг хөнгөлөх буюу бусад хэлбэрээр дэмжинэ.

7.2. Гадаад оюутанд үзүүлэх нийгмийн баталгааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцан шийдвэрлэнэ.

8 дугаар зүйл. Багш

8.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр ба түүнээс дээш зэрэгтэй байна. Ахисан түвшний сургалтыг тухайн чиглэлээр докторын зэрэгтэй багш удирдана.

8.2. Инженер, технологийн чиглэлээр сургалт зохион байгуулдаг коллежид семинар, дадлага, лабораторийн хичээлийг мэргэшсэн инженер удирдаж болно.

8.3. Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш заах арга зүй эзэмшсэн байна.

8.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн шатлалтай байна.

9 дүгээр зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн эрх, үүрэг

9.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын ерөнхий хуулийн 15.8-д зааснаас гадна дараах эрхтэй:

9.1.1. аж ахуйн нэгж байгууллагад мэргэжлийн дагуу зөвлөхөөр ажиллах;

9.1.2. бүтээлийн чөлөө авах;

9.1.3. хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх, нийгмийн зохих хангамж, хөнгөлөлт эдлэх;

9.1.4. дангаараа болон их сургууль, дээд сургууль, эрдэмтдийн баг, хуулийн этгээдтэй хамтран гарааны компани байгуулах;

9.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь Боловсролын ерөнхий хуулийн 15.9-д зааснаас гадна дараах үүрэг хүлээнэ:

9.2.1. эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэн явуулах;

9.2.2.мэргэжлийн дагуу соёл, боловсролыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажилд оролцох;

9.2.3 Сургалтын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалт болон хөтөлбөрийн сайжруулалтад оролцох;

10 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн нийгмийн баталгаа

10.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын багш өндөр насны тэтгэвэр тогтоолгоход тухайн сургалтын байгууллагын дотоод журамд заасны дагуу холбогдох хууль тогтоомжийг үндэслэн нэг удаа санхүүгийн дэмжлэгийг олгож болно.

10.2.Мэдлэг, ур чадвар, ажлын үр дүнд тохирсон цалин хөлс, хуульд заасан бусад хөнгөлөлт эдэлнэ.

11 дүгээр зүйл. Бусад оролцогч

11.1. Иргэн, хуулийн этгээд нь дээд боловсролын сургалтын байгууллагатай эрдэм шинжилгээ, судалгааны захиалга өгөх, суралцагчийг дадлага хийлгэх, мэргэжил дээшлүүлэх сургалт, ажлын байрны захиалга өгөх болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн бусад чиглэлээр хамтран ажиллана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

12 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын хөтөлбөр

12.1. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.2 Дээд боловсролын сургалтын хөтөлбөр нь Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д зааснаас гадна суралцахуйн үр дүнд суурилсан байх бөгөөд суралцагчид байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, техник технологийн чиглэлээр эрдэм шинжилгээ, сургалт, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарт мэргэжлийн түвшинд ажиллах мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэхэд чиглэнэ.

12.3 Сургалтын хөтөлбөрийг тухайн сургалтын байгууллага боловсруулж, эрдмийн зөвлөлийн зөвшөөрснөөр сургуулийн захирал батална.

12.4.Дээд боловсролын сургалтын байгууллага нь үндэсний мэргэшлийн хүрээ, дээд боловсролын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөрөө хэрэгжүүлж, чанарын дотоод баталгаажуулалтыг хийж гүйцэтгэнэ.

13 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулга

13.1. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь нэгдмэл байна.

13.2. Сургалтын хөтөлбөрийн агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрд Боловсролын ерөнхий хуулийн 17.9-д зааснаас гадна дараах агуулгыг тусгана.

13.2.1. ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны суурь мэдлэгийг эзэмшүүлэх;

13.2.2. мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид байгаль, нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухаан, технологийн чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол-арга зүйн мэдлэг эзэмшүүлэх;

13.2.3. мэргэших хэсгийн агуулга нь суралцагчид нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх, зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдэлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар эзэмшүүлэх; дахин томъёолох

13.3. Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна.

13.4. Багц цагийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

14 дүгээр зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт зохион байгуулалт

14.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь Боловсролын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан сургалтын хэлбэрээр сургалт зохион байгуулна.

14.2. Магистр, докторын сургалтын судалгаа, туршилтын ажлын зарим хэсгийг эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрийн газрын лаборатори, баазыг түшиглэн тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэмтдийн удирдлага дор явуулж болно.

14.3. Хичээлийн жилийн үргэлжлэх, дуусах болон шалгалтын хугацааг сургалтын хөтөлбөр түүний төлөвлөгөөгөөр зохицуулна.

14.4. Дээд боловсролын сургалтын байгууллагын хичээлийн жил нь Боловсролын ерөнхий хуулийн 8.4-т заасан бүтэцтэй байна.

14.5. Нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, онцгой дэглэм, хорио цээр тогтоосон нөхцөлийг харгалзан хичээлийн жилийн эхлэх, дуусах хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөн тухайн дээд боловсролын сургалтын байгууллага тухайн үед нь өөрчилж болно.

15 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрдэм шинжилгээ, инноваци

15.1 Дээд боловсролын сургалтын байгууллага нь эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.

15.2 Шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлээр болон ахисан түвшний хөтөлбөрийн холбогдох чиглэлээр дангаараа болон хамтарсан төсөл хэрэгжүүлнэ.

15.3 Оюуны өмчийг бүртгэх, баталгаажуулах, хамгаалах, бизнесийн эргэлтэд оруулах технологи дамжуулах бүтцийг бий болгож, их сургууль-аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсэн тогтолцоог бүрдүүлсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА

16 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллага

16.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь Боловсролын ерөнхий хуулийн 20.8-д заасан ангилал, хэв шинжтэй байна.

16.2. Их сургууль нь бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий сургалт-эрдэм шинжилгээ-инновацийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын сургалтын байгууллага байна.

16.3 Их сургууль нь ахисан түвшний сургалт дагнан эрхэлж болно.

16.4. Дээд сургууль нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр хэрэглээний судалгаа, шинжилгээний ажил явуулж, бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллага байна. Дээд сургууль нь магистрын сургалт эрхэлж болно.

16.5. Коллеж нь ажил мэргэжлийн салбар, чиглэлээр дипломын болон бакалаврын сургалт эрхэлдэг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

16.6. Техник технологийн коллеж нь үйлдвэрлэлийн тодорхой салбарт технологи хөгжүүлэх судалгааны ажил хийж, инженер технологийн чиглэлээр дипломын болон бакалаврын сургалт эрхэлнэ.

16.7. Орон нутагт дээд боловсролын сургалтын байгууллага, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллагын хамтын хөгжил, нөөцийн хуваарилалтын оновчтой тогтолцоог бүрдүүлж газар зүйн байршлаар бүсийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний цогцолбор байгуулж болно.

16.8. Бүсийн сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний цогцолбор байгуулах шаардлага, түүний бүрэлдэхүүн дэх байгууллагад тавих шаардлага, үндсэн чиг үүрэг, хамтын үйл ажиллагааны чиглэлийг зохицуулсан журмыг Засгийн газар батална.

16.9. “Монголын” болон “Үндэсний” гэсэн монгол, англи нэр, барааны тэмдгийг зөвхөн төрийн өмчийн их сургууль Засгийн газрын шийдвэрээр хэрэглэнэ.

16.10. Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалт, эрдэм шинжилгээний ажлын 75-аас доошгүй хувийг үндсэн багшаар гүйцэтгүүлнэ.

16.11. Дээд боловсролын сургалтын байгууллага нь Боловсролын ерөнхий хуулийн 23.1-д зааснаас гадна оюутны дотуур байртай байна.

16.12. Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг боловсролын магадлан итгэмжлэх эрх бүхий этгээдийн санал, дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

16.13. Дээд боловсролын сургалтын байгууллага нь эмчтэй байна.

16.14. Дээд боловсролын сургалтын байгууллага оюутны өөрийн удирдах байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, хэрэгжилтийг ханган ажиллана

16.15. Судалгааны их сургуультай холбогдох харилцааг энэ хуулиас гадна Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулиар зохицуулна.

17 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

17.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна.

17.2 Их сургууль нь профессорын багт тулгуурласан зохион байгуулалтын нэгжтэй байж болно.

17.3. Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, гарааны компани, сургалт-судалгааны бизнес-инкубатор, технологи дамжуулах төв, шинжлэх ухаан, технологийн парк, ахлах сургуультай байж болно.

17.4. Эрүүл мэндийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг төрийн өмчийн их сургууль нь эмнэлэгтэй байна. Эрүүл мэндийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг хувийн өмчийн их сургууль нь эмнэлэгтэй байж болно.

17.5. Цэрэг, цагдаа болон хөгжмийн сургалттай их сургууль нь чиг үүргийн онцлогоос хамаарч ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.6. Дээд сургууль нь коллеж, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагатай байж болно.

17.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын харьяаллын сургууль нь бие даасан хуулийн этгээд байна. Харьяаллын сургууль бие дааж магадлан итгэмжлэлд орно.

17.7 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт-эрдэм шинжилгээ, дадлагын бааз болгож болно.

17.8. Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тухайн сургалтын байгууллагын дүрмээр тогтооно.

17.9. Дээд боловсролын сургалтын байгууллагын салбар сургууль нь тухайн сургуулийн үндсэн чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлнэ.

18 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт

18.1. Их сургууль, дээд сургууль, коллежид бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг түүний мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ, сурах чадварыг харгалзан элсүүлнэ.

18.2. Элсэгчдийн тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон шаардлага, дээд боловсролын сургалтын орчны болон холбогдох бусад стандартад нийцүүлэн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөл тогтооно.

18.3. Оюутан, магистрант, докторант элсүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

18.4. Техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох замаар техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтад орсон төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулж болох бөгөөд багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

19 дүгээр зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг

19.1. Дээд боловсролын сургалтын байгууллага дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

19.1.1. дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх төрийн бодлого, дээд боловсролын хөгжлийн дунд болон урт хугацааны төлөвлөгөөнд нийцүүлэн сургуулиа хөгжүүлэх чиглэл, хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

19.1.2. сургалтын хөтөлбөр, түүний агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг сонгож хэрэгжүүлэх;

19.1.3. эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх, оролцох;

19.1.4. суралцагч элсүүлэх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу зохион байгуулах;

19.1.5. багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, технологийн судалгаа хийх;

19.1.6. гадаадын болон дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах;

19.1.7. иргэдийн боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх болон нийгмийн хариуцлага, хүмүүнлэгийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх;

19.1.8. Статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх;

19.1.9. Тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байх;

19.2. Дээд боловсролын сургалтын байгууллага санхүүгийн хувьд бие даасан байдлаа хадгалах талаар дараах үйл ажиллагаа эрхэлнэ.

19.2.1 Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт-судалгааны бизнес-инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн кластерийн тогтолцоогоор байгуулан ажиллуулах;

19.2.2 судалгаа шинжилгээ, зөвлөх үйл ажиллагааны үр дүн, бүтээгдэхүүнийг зах зээлд худалдан борлуулах зорилгоор дэргэдээ гарааны компани, технологи дамжуулах төв байгуулж ажиллуулах;

19.2.3. хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах зорилгоор үндсэн хөрөнгөө барьцаалан банкнаас зээл авах;

19.2.4. Сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орлого олж болно.

19.2.5. төрөл бүрийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх;

19.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчид тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

19.3.1. суралцагч нь тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг авах нөхцөл, болзлыг хангасан бол түүнийг олгох ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах;

19.3.2. суралцагчид тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг олгох ажлын үр дүнг санхүүжүүлэгч байгууллага, этгээдэд тайлагнах;

19.3.3. тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг олгох нөхцөл, болзлын талаар суралцагчид мэдээлэл, зөвлөгөө өгөх, иргэдэд сурталчлах;

19.4. Магадлан итгэмжлэл хийлгэнэ

19.4.1. Дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын магадлан итгэмжлэл хийх эрх бүхий этгээдээр байгууллагын магадлан итгэмжлэлийг 5 жил тутам заавал хийлгэнэ.

19.4.2. Шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө боловсролын магадлан итгэмжлэх эрх бүхий этгээдээр хөтөлбөртөө урьдчилсан магадлан итгэмжлэлийг хийлгэнэ.

19.4.3. Мэргэжлийн тусгай эрх, лицензтэй мэргэжилтэн бэлтгэх бакалаврын хөтөлбөрүүдийг заавал магадлан итгэмжлүүлнэ.

19.4.4. Дээд боловсролын байгууллага нь хэрэгжүүлж буй сургалтын хөтөлбөрийн чанар, нийцлийг сайжруулах зорилгоор сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлнэ.

19.4.5. Дээд боловсролын сургалтын байгууллага нь хэрэгжиж буй хөтөлбөрөө цахим хэлбэрээр хэрэгжүүлэх бол магадлан итгэмжлэл хийлгэж болно.

20 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, зарим үйл ажиллагааг зогсоох, татан буулгах

20.1. Дээд боловсролын сургалтын байгууллагыг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлнэ.

20.2. Төрийн болон орон нутгийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

20.3. Ашгийн төлөө бус их сургууль, дээд сургууль, коллежийг татан буулгах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

20.4. Дээд боловсролын байгууллага татан буугдсан нөхцөлд оюутны мэдлэг, чадварыг шалган тогтоож, ижил мэргэжлийн сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дээд боловсролын сургалтын бусад байгууллагатай хамтран шийдвэрлэнэ. Холбогдон гарах зардлын асуудлыг татан буугдсан сургууль нь хариуцна.

20.5. Төрийн өмчийн дээд боловсролын байгууллага татан буугдсан нөхцөлд төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтаар зохицуулагдана.

20.6 Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын салбар сургууль байгуулах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр үүсгэн байгуулагч нь шийдвэрлэнэ.

20.7.Татан буугдсан дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандаа гаргасан тушаал шийдвэр, суралцагчдын нэрс, төгсөгчдийн дипломын хуулбар, сургалтын төлөвлөгөө зэрэг сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архивт хүлээлгэн өгнө.

20.8.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага төгсөлт хийгээгүй суралцагчийг өөр сургуульд шилжүүлэхдээ түүнийг сургуульд анх элсүүлсэн тушаал шийдвэр, судалсан хичээл, шалгалттай холбоотой материалыг шилжүүлсэн шийдвэрийн хамт шилжин очих сургуулийн захиргаанд хүлээлгэн өгнө.

ТАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

21 дүгээр зүйл. Дээд боловсролын удирдлага

21.1.Дээд боловсролын удирдлагыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

21.2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Боловсролын Ерөнхий хуулийн 31 дүгээр зүйлд заасан бүрэн эрхээс гадна дээд боловсролын асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

21.2.1. төрийн захиргааны бусад төв байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах.

21.2.2. төрийн захиргааны бусад байгууллага болон дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй санхүүгийн дэмжлэг олгох, суралцагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах.

21.2.3. төрийн захиргааны бусад байгууллага болон дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй дээд боловсролын байгууллагын суралцагчид санхүүгийн дэмжлэг олгох, багш, суралцагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллана.

21.2.4. төрийн өмчит дээд боловсролын сургалтын байгууллагын захирлыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилох, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;

21.2.5. Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаал, дэд профессор, профессор цолын тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох.

22 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдлага

22.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг тухайн сургуулийн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

22.2. Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгчийн төлөөлөл ба хараат бус гишүүдтэй байна.

22.3. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын байгууллагад 51-60 хувь, хувийн өмчийн дээд боловсролын байгууллагад 60 хувь тус тус байна. Удирдах зөвлөлд орох үүсгэн байгуулагчийн төлөөллийг үүсгэн байгуулагчийн шийдвэрээр болон түүний эрх шилжүүлснээр томилно.

22.4 Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 20 хувь, төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын 10 хувь нь 3 жилийн хугацаатай томилогдсон ажил олгогч, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын төлөөллөөс сонгосон хараат бус гишүүд байх бөгөөд хараат бус гишүүдийг үүсгэн байгуулагч нээлттэй сонгон шалгаруулалтаар тодруулна.

22.5 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 10 хувь нь багш нарын төлөөлөл, 10 хувь нь оюутны төлөөлөл байх бөгөөд багшийн төлөөллийг 3 жилээр, оюутны төлөөллийг 1 жилээр хамт олны хурлаас тус тус сонгоно.

22.6 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 10 хувь нь төгсөгчдийн төлөөлөл байх бөгөөд тухайн сургалтын байгууллагын дүрмийн дагуу байгуулагдсан төгсөгчдийн байгууллагын шийдвэрээр 3 жилийн хугацаатай томилно.

22.7. Удирдах зөвлөлийн оюутны төлөөллөөс бусад гишүүнийг гурван жилийн хугацаагаар сонгох буюу томилно. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг жил бүр өөрчилж болно.

22.8. Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Удирдах зөвлөл бүрэн эрхийн хугацаанд жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагч, зөвлөлийн дарга буюу гишүүдийн 1/3-ээс доошгүйн саналаар хуралдуулна. Захирал тодорхой асуудлаар удирдах зөвлөлийг хуралдуулах саналаа зөвлөлийн даргад тавьж болно.

22.9. Удирдах зөвлөл дийлэнх олонхын саналаар шийдвэр гаргана. Төрийн өмчит сургуулийн удирдах зөвлөлийн даргыг боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн санал болгож удирдах зөвлөлөөс сонгоно.

22.10. Удирдах зөвлөл үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий орон тооны бус комисс, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

22.11. Удирдах зөвлөлд орсон үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь түүний бодлого, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

22.12.Удирдах зөвлөлийн даргыг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон, өөрөө чөлөөлөгдөхийг хүссэн үндэслэлээр хугацаанаас нь өмнө өөрчилж болно.

22.13.Үүсгэн байгуулагч удирдах зөвлөл, түүний гишүүнийг хангалтгүй ажилласан гэж үзвэл өөрийн төлөөллөө эгүүлэн татах, бусад гишүүний талаар сонгосон хамт олонд нь мэдэгдэх эрхтэй.

22.14.Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

22.14.1.холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсролын байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, дүрмийг батлах, өөрчлөх;

22.14.2.сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох.

22.14.3.хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив авах журам тогтоох;

22.14.4.сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох;

22.14.5.сургуулийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

22.14.6 удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж үүсгэн байгуулагчид өгөх.

22.15. Захирал нь энэ хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, удирдах зөвлөлд ажлаа тайлагнана.

22.16.Сургалт-эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зорилгоор судалгааны их сургууль, их сургууль, дээд сургуульд эрдмийн зөвлөл, коллежид сургалт-арга зүйн зөвлөл ажиллана.

22.17.Дээд боловсролын сургалтын байгууллагын захирал эрдмийн болон сургалт-арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батална.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ

23 дугаар зүйл. Дээд боловсролын санхүүжилт

23.1.Дээд боловсролын байгууллагын санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

23.1.1.үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;

23.1.2.улсын төсвийн хөрөнгө;

23.1.3 орон нутгийн төсөв

23.1.4. засгийн газрын бусад тусгай сангийн хөрөнгө

23.1.5. эрдэм шинжилгээ, судалгааны ажлын санхүүжилтэд зориулсан хөрөнгө;

23.1.6. сургалтын төлбөр;

23.1.7. гэрээт ажил, үйлчилгээ, аж ахуйн бусад үйл ажиллагаанаас олсон орлого;

23.1.8. аж ахуйн нэгж, байгууллагаас эдийн засгийн сонирхолгүйгээр шилжүүлсэн хөрөнгийг эргэлтэд оруулснаас олсон орлого;

23.1.9. аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хандив, тусламж;

23.1.10. их, дээд сургуулиудын дэргэд байгуулсан гарааны компаниудын хөрөнгийн анхдагч зах зээлээс бүрдүүлсэн хөрөнгө

23.1.11. бусад эх үүсвэр

23.2. Дээд боловсролыг санхүүжүүлэхэд зориулан улсын төсвөөс бүрдүүлэх хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу дараах зориулалтаар зарцуулна:

23.2.1. Дээд боловсролын салбарын талаар баримтлах чиглэл, стратегийн ач холбогдолтой хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд;

23.2.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын хуулийн этгээдийн эрхтэй, тусгай зориулалтын сангийн үйл ажиллагааг дэмжихэд;

23.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, сургалтын төлбөр, суралцагчийн тэтгэлэг, нийгмийн баталгаатай холбогдох мэдээллийн цахим сантай байх бөгөөд түүний мэдээлэл нь олон нийтэд нээлттэй, ил тод байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

24 дүгээр зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

24.1. Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Хөдөлмөрийн тухай, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

25.1. Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
